




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ийн ХЭВЛЭЛ
transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№01 (151) 2022 оны 01 сар

МЭНДЧИЛГЭЭ



Манай компани цахилгаан эрчим хүчийг найдвартай дамжуулах эрхэм үүргээ хариуцлагатай биелүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, шугам тоноглолын шинэчлэлт, угсралт засварын ажлуудыг хэвийн гүйцэтгэж шинэ онтой золгож байна.

Амжилт, ололт арвинтай үдэж байгаа 2021 онд манай хамт олон 220/110/35 кВ-ын Эрдэнэт дэд станцын 200 МВА-н хүчин чадалтай АТ-1 автотрансформаторын бүрэн задаргаат их засварын ажлыг Украин улсын ЗТЗ сервис компанитай хамтран хийж, ашиглалтад 100% хүлээн авсан. 220/110 кВ-ын ИХБ-4, 220/110/35 кВ-ын Эрдэнэт, Дархан дэд станцуудыг холбох 220 кВ-ын 201, 202, 203, 204, 208 дугаар агаарын шугамын цахилгаан соронзон механик реле хамгаалалтыг сүүлийн үеийн микропроцессор бүхий ДФЗМ маягийн TOP-300, SEL-411L реле хамгаалалтуудаар шинэчлэн сольсон нь 220 кВ-ын **АЛТАН ГУРВАЛЖИН**-ийн найдвартай ажиллагаа, эрчим хүчний системийн тогтворжилтыг хангасан томоохон ажил болсныг дурьдах нь зүйтэй. Түүнчлэн 220/22/35 кВ-н Цагаансуварга дэд станцыг 220 кВ-ын хүчдлийн түвшинд шилжүүлж, ачаалалд залгаснаар 11 дэх 220 кВ-ын станцаа ашиглалтанд хүлээж авлаа. 110/35/10 кВ-ын Баянчандмань дэд станцыг транзит дэд станц болгон схемийн өөрчлөлт хийж, 117,118-р агаарын шугамын үндсэн хамгаалалтыг ажилд оруулан 110 кВ-ын транзит дэд станцын тоог нэгээр нэмэгдүүлж чадлаа. Компанийн бүх салбарыг төв удирдлагатай холбосон холбооны нэгдсэн системийг шинээр нэвтрүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар салбарын шилэн кабельд холбогдсон 20 дэд станцыг SIP холбоогоор холбон шуурхай ажиллагааны суурь сүлжээг үүсгэж, компанийн нэгдсэн холбооны системд холбох ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. 220/110/35 кВ Багануур дэд станцын 220 кВ ИХБ-ын схемийн өөрчлөлт хийж, анхдагч хэлхээний схемийн найдвартай ажиллагааг, 220 кВ I, II систем шинд ДЗШ, УРОВ хамгаалалт шинээр суурилуулж, РХА-н найдвартай ажиллагааг тус тус дээшлүүллээ. 220/110 кВ-н ИХБ-4-ийн 220 кВ-ын 1, 2, 3, 4-р систем шин, Той.СШ-1-н нийт 14 иж бүрдэл бүхий хүчдэлийн трансформатор, 208, 114, 116 дугаар агаарын шугамын багтаамжийн хүчдэлийн трансформаторыг шинэчлэн системийн найдвартай ажиллагааг хангасан. Улаанбаатар дэд станцын 11 ком 110 кВ хуурай салгуур, Яармаг дэд станцын 10 кВ-ын 27 ком ячийкийг реле хамгаалалт автоматикийн хамтаар, Шарын гол дэд станцын Т-1, Т-2, 6 кВ-н секцийн реле хамгаалалт, дотоод хэрэгцээний тоноглол болон 110 кВ-н ЦШ-1, 2-г шинэчилж, олон жилийн насжилттай, хуучирсан тоноглолын эрсдлийг бууруулсан өндөр үр бүтээлтэй ажил болсон. 225 дугаар агаарын шугамын тулгуур №707-356-н хооронд 1-р фазын хоёр ширхэг элемент болон ПР маркийн дундын звено хасах ажлыг гүйцэтгэн коронжилт ихтэй байсан тулгуур № 708-712-н хооронд гурван фазын дамжуулагч утсыг уртын дагуу сольсноор тасралтын тоог бууруулах, системийн тогтвортой байдлыг хангахад ач холбогдол бүхий томоохон ажлын нэг боллоо. 110/35 кВ-ын ИХБ-3-ын төв удирдлагын панелийг иж бүрэн шинэчлэх, алсын удирдлага, хяналтын НМИ-тай системтэй болгох, удирдлагын байрны их засварын болон барилгын өргөтгөлийн, Сонгино дэд станц, ИХБ-4-т АУРА-07-г шинээр угсарч монтажлах ажлуудыг хугацаанд нь бүрэн хийж дуусгалаа.

Эрчим хүчний салбарын болон компанийн хамт олондоо хөгжил дэвшил бүхний нэгэн түүчээ болох ирж буй шинэ ондоо эрүүл энх, саруул сайхан байж, Монгол улсын эрчим хүчний салбарыг мандуулах их үйлст өндөр амжилт хүсье.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ

НҮҮР-3

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2021 ОНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЧ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ «ШИЛДЭГ МЕНЕЖЕР»-ЭЭР, УЛААНБААТАР САЛБАРЫН АШУА-НЫ ДЭД СТАНЦЫН ЭЭЛЖИЙН МОНТЁР Н.БАТЖАРГАЛ «ШИЛДЭГ АЖИЛТАН»-ААР ТҮС ТҮС ШАЛГАРЛАА.

НҮҮР-10

«Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл»-ийн Зөвлөхийн гэрээг байгуулав.

НҮҮР-10

КОМПАНИЙН 2021-2022 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАГДЛАА

НҮҮР-10

ЦДҮС ТӨХК «ТЭРБУМ МОД» ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ

НҮҮР-11

ТӨВ КОМПАНИ БОЛОН САЛБАРУУД СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

НҮҮР-12

МОНГОЛ БИЧГИЙН БУЛАН



2021 ОНЫ ЦДҮС ТӨХК-ИЙН ШИЛДЭГ 10 АЖИЛ

1. 220/110/35 кВ-ын “Эрдэнэт” дэд станцын 200 МВА-н хүчин чадалтай АТ-1 автотрансформаторыг компанийн үйл ажиллагааны чадавхи, дотоод нөөцөөр Украин улсын ЗТЗ сервис компанитай хамтарч бүрэн задаргаат их засварын ажлыг хийж ашиглалтанд 100% хүлээн авсан. Тус ажил нь улсын эдийн засгийн томоохон эх үүсвэр болсон Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Хангайн бүс нутгийн хэрэглэгчид төдийгүй эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай тасралтгүй байдал хангагдлаа.



Зураг-1. Трансформаторын туслах эд, ангиудыг салгаж, ороомгийн бэхлэгээнд засвар хийсэн байдал

2. 220/110 кВ-ын ИХБ-4, 220/110/35 кВ-ын Эрдэнэт, Дархан дэд станцуудыг холбодог 220 кВ-ын 201, 202, 203, 204, 208-р агаарын шугамын хуучин цахилгаан соронзон механик реле хамгаалалтыг сүүлийн үеийн микропроцессор бүхий ДФЗМ маягийн TOP-300, SEL-411L реле хамгаалалтуудаар шинэчлэн сольсноор 220 кВ-ын АЛТАН ГУРВАЛЖИН-гын найдвартай ажиллагаа, эрчим хүчний системийн тогтворжилтыг хангасан томоохон ажил юм.



Зураг-2 МП-ын хамгаалалт шалгаж, туршиж байгаа байдал

3. “220/22/35 кВ-н Цагаансуварга” дэд станцыг 220 кВ-ын хүчдлийн түвшинд шилжүүлж ачаалалд залгаснаар манай компанийн 220 кВ-ын 11 дахь станц ашиглалтад орсон үйл явдал болж өнгөрлөө.

220 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжсэнээр хиймэл дагуулын синхрон цаг, Hitachi брэндийн хүлэмжийн хий ялгаруулалтын хянах төхөөрөмжийг зураг схемийн дагуу ажилд оруулсан. Уг хянах төхөөрөмж нь хүлэмжийн хийн ялгаралтыг ямар хэмжээгээр бууруулж байгааг тодорхойлох боломжтой бөгөөд алдагдал багатай дамжуулагчийн судалгааг Монгол улсад нутагшуулах томоохон ажлын үндэс болсон.



Зураг-3 220/22/35кВ -ын Цагаансуварга дэд станц




Зураг-4 Hitachi monitoring төхөөрөмж

4. 110/35/10 кВ-ын Баянчандмань дэд станцын 110 кВ-ын агаарын шугамыг транзит дэд станц болгон өөрчилсний дагуу 117, 118-р агаарын шугамын үндсэн хамгаалалтыг ажилд оруулж 110 кВ-ын транзит дэд станцын тоог нэгээр нэмэгдүүллээ.



Зураг-5 117-р агаарын шугамын шинээр суурилуулсан реле хамгаалалтын панель

5. Компанийн бүх салбарыг Төв удирдлагатай холбосон холбооны нэгдсэн системийг шинээр нэвтрүүлсэн. Мөн Улаанбаатар салбарын шилэн кабельд холбогдсон 20 дэд станцыг SIP холбоогоор холбож шуурхай ажиллагааны холбооны суурь сүлжээг үүсгэж, компанийн нэгдсэн холбооны системд холбосон.



Зураг-6 20 дэд станцыг SIP холбоогоор холбосон



Зураг-7 Шуурхай ажиллагааны холбоо

6. 220/110/35 кВ “Багануур” дэд станцын 220 кВ ил хуваарилах байгууламжийн схемийн өөрчлөлт хийж анхдагч хэлхээний схемийн найдвартай ажиллагааг хангасан. Мөн 220/110/35кВ “Багануур” дэд станцын 220 кВ I,II систем шинд ДЗШ,УРОВ хамгаалалт шинээр суурилуулж реле хамгаалалт автоматикийн найдвартай ажиллагааг дээшлүүллээ.



Зураг-8 Багануур дэд станцын схем өөрчлөлтийг хийж байгаа бригад

7. 220/110 кВ-ын ИХБ-4-ийн 220 кВ-ын 1, 2, 3, 4-р систем шин, Той.СШ-1-ийн нийт 14 ком хүчдэлийн трансформатор, мөн 208-р агаарын шугам, 114, 116-р агаарын шугамын багтаамжийн хүчдэлийн трансформаторын шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэнээр системийн найдвартай ажиллагааг дээшлүүллээ.



Зураг-9 TYD-245/3-0.01H маркийн хүчдэлийн трансформатор суурилуулсан.

8. Улаанбаатар дэд станцын 11 ком 110 кВ хуурай салгуур болон Яармаг дэд станцын 10 кВ-ын 27 ком ячеийгийг нь реле хамгаалалт автоматикийн хамт мөн Шарынгол дэд станцын Т-1,Т-2, 6 кВ-н секцийн релей хамгаалалт, дотоод хэрэгцээний тоноглолын шинэчлэл, Т-1,2-н 110 кВ-н цэнэг

шавхагч-1,2-н шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэнээр олон жилийн насжилттай хуучирсан тоноглолыг шинэчилж эрсдлийг бууруулсан өндөр үр бүтээлтэй ажил болсон юм.



Зураг-10 GW4A-126DW/200 маркийн хуурай салгуур, Яармаг дэд станцын 10 кВ ячеийкуудын шинэчлэл

9. 225-р ЦДАШ-н тулгуур №707-356-ийн хооронд 1-р фазын 2ш элемент болон ПР маркийн дундын звено хасах ажил болон коронжилт ихтэй байсан тулгуур № 708-712-н хооронд 3 фазын дамжуулагч утсыг уртын дагуу сольсноор тасралтын тоог бууруулж системийн тогтвортой байдлыг хангасан томоохон ажлын нэг боллоо.



Зураг-11 225-р шугамын утас солих болон элемент, звено хасах ажил хийгдэж байгаа нь

10. ЭХС-ийн тогтвортой найдвартай ажиллагаанд бодит үнэлэлт дүгнэлт өгөх зорилтын хүрээнд 110/35 кВ-ын ИХБ-3-ын төв удирдлагын панелийг иж бүрэн шинэчлэх, алсын удирдлага хяналтын НМИ-тай системтэй болгох, удирдлагын байранд их засвар хийж, барилга өргөтгөх ажил. Сонгино дэд станц болон ИХБ-4-д АУРА-07-г шинээр угсарч монтаглах ажлыг амжилтайгаар бүрэн хийж дуусгалаа.



Зураг-12 ИХБ-3 НМИ



Зураг-13 Сонгино дэд станцын АУРА-07

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2021 ОНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЧ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ “ШИЛДЭГ МЕНЕЖЕР”-ЭЭР, УЛААНБААТАР САЛБАРЫН АШУА-НЫ ДЭД СТАНЦЫН ЭЭЛЖИЙН МОНТЁР Н.БАТЖАРГАЛ “ШИЛДЭГ АЖИЛТАН”-ААР ТУС ТУС ШАЛГАРЛАА.

Монгол Улсын гал голомт болсон эрчим хүчний салбар 2021 онд хийсэн ажлаа дүгнэн шилдэг байгууллага, бүтээн байгуулалт, менежер, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтан, ажлаа тодруулж, /2021.12.27/-ны өдөр шагналыг гардууллаа. Шилдгээр шалгарсан байгууллага, хамт олныг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, дэд сайд М.Баярмагнай, Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох нар хүлээн авч баяр хүргэсэн юм.

Ажлын үр дүн, онцгой амжилт бүтээлийг нь үнэлж 2021 оны салбарын шилдэгүүдээ шалгаруулсан юм.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу-г “ШИЛДЭГ МЕНЕЖЕР”-ээр,

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн дэд станцын ээлжийн монтёр Ням овогтой Батжаргал нарыг “ШИЛДЭГ АЖИЛТАН”-аар тус тус шалгарч шинэ оны босгон дээр шагналаа гардаг авлаа.



КОМПАНИЙН 2021 ОНЫ ШИЛДЭГҮҮД ТОДОРЛОО.



Төвийн бүсийн салбарын өндөр үелзлэлийн холбооны инженер Д.Батболд



ШЗХ-ийн диспетчер инженер М.Сэржхорол



Зүүн-Өмнөд бүсийн салбарын Төв дэд станцын ээлжийн монтёр Х.Эрдэнэбаатар



Улаанбаатар салбарын засварын албаны шугамын засварын монтёр-гагнуурчин М.Мөнгөн-Эрдэнэ

2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр компанийн оны хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилтан, шилдэг дэд станцыг тодруулж шагнал гардууллаа. Мөн үеэр “Тесла ба Эдисон” болон “Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх” уралдааны шилдгүүд шалгарч шагнагдсан юм. Компанийн 2021 оны Хөдөлмөрийн аварга Инженер техникийн ажилтнаар Төвийн бүсийн салбарын өндөр үелзлэлийн холбооны инженер Д.Батболд, Шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтнаар ШЗХ-ийн диспетчер инженер М.Сэржхорол, Ашиглалтын монтёроор Зүүн-Өмнөд бүсийн салбарын 110/6 кВ-ын Төв дэд станцын ээлжийн монтёр Х.Эрдэнэбаатар, Засварын монтёроор Улаанбаатар салбарын засварын албаны шугамын засварын монтёр-гагнуурчин М.Мөнгөн-Эрдэнэ, Албан хаагчаар Хангайн бүсийн салбарын санхүү, эдийн засгийн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч В.Хандмаа, Ажилтнаар Хангайн бүсийн салбарын тусгай зориулалтын машин механизмын жолооч Г.Цэрмаа, Удирдах албан тушаалтнаар Говийн бүсийн салбарын РХАХТ-ын албаны дарга Т.Цэнгэл нар тус тус шалгарлаа. Хөдөлмөрийн аварга ажилтнаар шалгарсан та бүхэнд ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.



Хангайн бүсийн салбарын санхүү, эдийн засгийн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч В.Хандмаа,



Хангайн бүсийн салбарын тусгай зориулалтын машин механизмын жолооч Г.Цэрмаа



Говийн бүсийн салбарын РХАХТ-ын албаны дарга Т.Цэнгэл

САЛБАРЫН 2021 ОНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУД ТОДОРЛОО

АЖИЛ ҮЙЛСЭЭРЭЭ ХАМТ ОЛНОО МАНЛАЙЛСАН 2021 ОНЫ САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУДАА БАЯР ХҮРГЭЖ, АЙЛЧЛАН ИРЖ БУЙ ШИНЭ ОНДОО АМЖИЛТ ОЛОЛТ АРВИН БАЙХЫН ЕРӨӨЛ ДЭВШҮҮЛЬЕ.



Хангайн бүсийн салбарын 2021 оны “Тэргүүний ажилтан” А.Бямбаа



Төвийн бүсийн салбарын 2021 оны тэргүүний ажилтан Д.Батболд



Говийн бүсийн салбарын 2021 Оны тэргүүний ажилтан Б.Үүрийнтуяа



Улаанбаатар салбарын 2021 оны “тэргүүний ажилтан” М.Майхүү



Зүүн-өмнөд бүсийн 2021 оны тэргүүний ажилтан Х.Эрдэнэбаатар



Төв компанийн 2021 оны тэргүүний ажилтан Б.Ганбулга



“ТЕСЛА БА ЭДИСОН” БОЛОН “ЗАСВАР, АШИГЛАЛТЫН АЖЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ” УРАЛДААНЫ ДҮН ГАРЛАА.

2021.12.27-ны өдөр “Тесла ба Эдисон” болон “Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх” уралдааны шилдгүүдийг тодруулж шагналыг гардууллаа. “Тесла ба Эдисон” уралдааны “Шилдэг төсөл” төрөлд нэгдүгээр байрт “Технологийн хувийн хаалттай сүлжээ буюу TVPN” төслийг боловсруулсан Төвийн бүсийн салбарын ерөнхий инженер М.Чулуунбаатар

удирдагчтай, Инженерийн хэсгийн мэдээллийн технологи, компьютерын инженер Э.Амарсанаа, Инженерийн хэсгийн реле хамгаалалт, автоматикийн инженер Б.Эрдэнэтулга нарын бүрэлдэхүүнтэй багш шалгарч Тесла цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан бол дэд байрт “Subs Mon application”-ийг боловсруулсан Баянхонгор дэд станцын ээлжийн монтёр

Б.Баянмөнх орсон юм.

“Шилдэг бүтээл” төрөлд нэгдүгээр байрт “Цахилгаан тоноглолыг хүчдэлийн хэлбэлзлээс хамгаалах Тог-1 реле”-г зохион бүтээсэн Улаанбаатар салбарын диспетчер инженер Ц.Баттогтох шалгарсан бол “Сургалт программ хувилбар-2” бүтээлийг зохиосон Улаанбаатар салбарын диспетчер

инженер Н.Батсүрэн
юм.

удаалсан

“Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх” уралдааны тэргүүн байрт Хангайн бүсийн салбар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.



Шилдэг төсөл төрөлд тэргүүн байр эзэлсэн багийн ахлагч ТБС-ын ерөнхий инженер М.Чулуунбаатар



Баянхонгор дэд станцын ээлжийн монтёр Б.Баянмөнх-ийн шагналыг ХБС-ын ерөнхий инженер Б.Анхбаяр гардан авч буй мөч



“Шилдэг бүтээл” төрөлд тэргүүн дэд байрт шалгарсан Улаанбаатар салбарын диспетчер инженер Ц.Баттогтох, Н.Батсүрэн нар компанийн удирдлагуудын хамт



“Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх” уралдааны тэргүүн байрт Хангайн бүсийн салбарын дарга П.Баясгалан компанийн удирдлагуудын хамт

ОНЫ ШИЛДЭГ ДЭД СТАНЦААР ТӨВИЙН БҮСИЙН САЛБАРЫН “ДАРХАН” ДЭД СТАНЦ ШАЛГАРЛАА.

2021 оны “Шилдэг дэд станц” номинацид нэгдүгээр байрт Төвийн бүсийн салбарын “Дархан” дэд станц шалгарсан бол хоёрдугаар байрт Говийн бүсийн салбарын “Оюутолгой” дэд станц удаалж, Улаанбаатар салбарын “Илч баян” дэд станц гуравдугаар байрт орлоо. “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж шагналт байрт шалгарсан шилдэг дэд станцын ажилтан албан хаагчид баяр хүргэж ажлын амжилт хүсье.

1. 2021 оны “ШИЛДЭГ ДЭД СТАНЦ” шалгаруулах номинацад “НЭГДҮГЭЭР БАЙР” эзэлсэн Төвийн бүсийн салбарын “ДАРХАН” дэд станц



2. 2021 оны “ШИЛДЭГ ДЭД СТАНЦ” шалгаруулах номинацад “ХОЁРДУГААР БАЙР” эзэлсэн Говийн бүсийн салбарын “ОЮУТОЛГОЙ” дэд станц




3. 2021 оны “ШИЛДЭГ ДЭД СТАНЦ” шалгаруулах номинацад “ГУРАВДУГААР БАЙР” эзэлсэн Улаанбаатар салбарын “ИЛЧБАЯН” дэд станц



ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

/2021 оны 10,11 сар/

Сар бүрийн 2 дахь 7 хоногийн Мягмар гаригт зохион байгуулагддаг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр”-өөр ажилтнуудад зааварчилгаа өгөх, хууль, дүрэм, журам танилцуулах, сургалт зохион байгуулах ажлуудыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр тогтмол зохион байгуулан ажиллаж байна



Чингэлтэй дүүрэг, Төв аймгийн Онцгой байдлын хэлтэст Умард, Телевиз, Илчбаян, Хөшигт, Баянчандмань дэд станцуудын галын аюулгүй байдлын холбогдох материалуудыг хүргүүлэн үзлэгт хамрагдаж, ажлын байрны галын дүгнэлтийг гаргуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 3/2417 тоот “Улсын үзлэг зохион байгуулах тухай” албан бичгийг дагуу үзлэг шалгалтад хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, хүний нөөцийн 67 чиглэлээр амжилттай хамрагдсан.


Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/425 дугаар Захирамжийн дагуу Улаанбаатар салбарын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн “Гамшгаас хамгаалах бэлэн байдал”-ын үзлэг шалгалтад 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хамрагдаж, “Дүүрэн хангалттай” үнэлгээ авсан.



Салбарын бие бүрэлдэхүүн



Бичиг баримтын шалгалт



Гэмтэл устгаж байгаа нь

220 кВ-ын агаарын шугам 208-ын тулгуур №494-ийн 8 ширхэг хэрээс төмөр алдагдсан гэмтлийг 2021.11.16-ны өдөр ээлжит үзлэгээр илрүүлсэн. 2021.11.16-ны өдрийн 17 цагаас шөнийн 00 цагийн хооронд бригадыг яаралтай зохион байгуулан гэмтлийг устгаж, тулгуурын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. Илэрсэн зөрчлийг СХД-ын Цагдаагийн 1-р хэлтэст мэдэгдэж, хэрэг үүсгэн мэдүүлэг өгч, акт, албан бичиг хүргүүлсэн. СХД-ын Цагдаагийн 1-р хэлтсийн эрүүгийн мөрдөн байцаагч Э.Хатанбаатартай хамтарч, тулгуур№494-д тушаа төмөр алга болсон газар нутгаар тодруулга хийх ажлыг зохион байгуулсан.



Тодруулга авч байгаа нь

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын 110 кВ-ын 11 ком хуурай салгуурыг шинэчлэх Эрчим elektrik ХХК-ийн ажлын гүйцэтгэлийг шалгаж, байнгын ашиглалтад хүлээн авах техникийн комисс 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ажилласан. Энэ ажлыг хийж гүйцэтгэсэнээр 38 жилийн өндөр насжилттай хуучирсан тоноглолыг шинэчлэн тоноглолын аюулгүй байдлыг дээшлүүлж, ажлын байрны эрсдэлийг бууруулсан өндөр үр бүтээлтэй ажил болсон.




Шинэчилсэн хуурай салгуурууд


110/35/6 кВ-ын Суруга дэд станцын 110/35/6 кВ-ын 2-р секцийн бүх тоноглолд урсгал засвар хийх, 110/35 кВ-ын шугамын болон шинийн порталыг мөнгөн боронзоор, тоноглолуудын суурийн төмөр хийцийг саарал өнгөөр будах, РХА-ийн засвар туршилт тохируулгын ажлууд, 110 кВ-ын Суруга-Б шугамд дээд үзлэг хийж гэмтэл устгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.




ТЗБАХ-ний ажлын хүрээнд Сонгино дэд станцад АУРА-256 аваарийн бүртгэх төхөөрөмжийн панель суурилуулах ажил хийсэн. Уг ажлын хүрээнд 110 кВ-ын ШХТ, 110 кВ-н ТойТ, 110 кВ-ын 2 хэлхээт 10 шугам тоноглол, 220 кВ-ын ШХТ, 220 кВ-ын ТойТ, 220 кВ-ын 2 хэлхээт 8 шугам тоноглол, автотрансформатор 1,2, 220/110 кВ-ын тоолуурын панель, дотоод хэрэгцээний 1 хуваарилах самбар, DC панель, 220/110 ДЗШ-н хамгаалалтын панель тус бүрд нь гүйдлийн хэлхээний кабель, дискрет сигналын кабель, хувьсах хүчдэл болон тогтмол хүчдэлийн хэлхээний кабелиудыг татаж, хоёрдогч хэлхээний холболт хийгдсэн. Мөн шугам, тоноглолын хамгаалалтын панель тус бүрд нь дотор монтажийн холболт хийж, РХА-ийн төхөөрөмжид тохируулга хийж, АУРА-256-д шугам тоноглолын гүйдлийн болон хүчдэлийн оролтын аналог тохируулга, дискрет сигналын тохируулга тус бүрд нь хийж гүйцэтгэсэн.




Улаанбаатар дэд станцад 107, 108-р АШ-ын ЧДЗ оруулах ажлын хүрээнд Улаанбаатар дэд станцад 107,108-р АШ-ын ЧДЗ-н тавилтай холбоотой SEL-751A реле суурилуулж холболт хийж, ажиллуулж шалгасан.



110 кВ-ын 149,150-р шугамын Дарь-Эх салбар шугамын тулгуур№6-д хазайлт үүсч зөвшөөрөгдөх норм хэмжээнээс хэтэрсэн тул тухайн тулгуурыг тэгшлэх ажлыг гүйцэтгэсэн.



110 кВ-ын 134, 134-р шугамын №13,15,20,21-р тулгууруудын хэрээс төмрийн боолт суларч, унжсан байсанд боолт нөхөж хийх, чангалгаа хийх ажлыг гүйцэтгэсэн.



Туул дэд станцын төв дохиоллын их засварын ажлын хүрээнд 110 кВ-ын 10 ширхэг панелийн магистрал шинийг холбох, схем зураг гаргах, панелийг суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.



Тулгуур №123,125-д үеийн хамгаалалтын ажил хийгдэж байна. 2021.06.10-ны өдөр 80мЗ, 2021.11.12-ны өдөр 200мЗ уулын чулуу буулгаж, түрж үерийн хамгаалалт хийх ажил хийгдсэн.




Төв компанийн аж ахуйн хашаанд 2021 оны 12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд аянга зайлуулагч угсарч босгох ажил хийж гүйцэтгэсэн.



110/35/10 кВ-ын Сургуа дэд станцаас 35 кВ-ын ХТ-1, 2-г /нийт 6ш ХТ/ сууринаас нь авч Туул дэд станцын Трансформатор засварын цех рүү зөөвөрлөн задалж ороомгийн хөндийрүүлэлт, тосны цахилгаан даац сайжруулах ажил хийж суурилуулсан.





ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Эргономикийн 15 аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх судалгаа хийж байна. Аж ахуйн ажил гүйцэтгэх үеийн эрсдэлийн үнэлгээ тодруулвал сантеникч, жолооч, үйлчлэгч, компьютерийн ажилбар тус бүрээр ажлын байрны эрсдэлийн үнэлгээ боловсруулсан.

2017-2020 оны технологийн зөрчлийг судалсан акт, 2017-2020 оны салбарын дотоод хяналт шалгалтын материал, 2012-2020 оны хяналтын байгууллагын албан шаардлага, хэрэгжилт, үйлдвэрлэлийн ослын баримт, 2017-2020 онд салбар дотоодод бүртгэгдсэн технологийн зөрчил, 2020 оны ээлжит шалгалтын материал, 2019-2020 оны хяналтын байгууллагын шалгалтын материал зэрэг нийт 12 нэгж баримт үдэж архивт хүлээлгэн өгсөн.

Салбарын хэмжээнд ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг WHA ХХК гүйцэтгэлээ. Үүнд:

Дархан, Үйлдвэр дэд станцуудын аккумуляторын өрөө, удирдлага дохиоллын байр, РХА-ын байгууламжийн өрөө, холбооны өрөө, ил хуваарилах байгууламж, хаалттай хуваарилах байгууламж зэрэг ажлын байрны соронзон орны хэмжээ, агаарын чийгшил, гэрэлтүүлгийн хүч зэрэг хэмжилт хийж ажлын байрны онцлог нөхцөлд тохируулан төлөөлөл болгож 16 ажилтнаас асуумж чанарын үнэлгээний ярилцлага хийгдлээ.

Мөн сургалтын зориулалтын ЦДАШ-ын тулгуур дээр ажиллуулан хэмжилт хийж хөдөлмөрийн нөхцлийг үнэлэв.



Дархан-Уул аймгийн ЭМГ-аас зохион байгуулсан “коронавируст халдвар(Ковид-19)-ын үед хүний нөөцийг чадавхижуулах ариутгагч, халдваргүйтгэгч бэлтгэх” нэг өдрийн сургалтанд ЭМЗ-ийн гишүүн П.Алтанцэцэг хамрагдаж мэдээллийг нийт ажилтнуудад сурталчиллаа.

Ковид-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Зөвлөмж №08, 09-ыг салбарын нийт ажилтнуудад танилцуулж халдвар хамгааллын дэглэм барих талаар нийт 197 ажилтанд зааварчилга өгсөн.

Ковидын батлагдсан тохиолдол болох 15 ажилтны тандалт судалгаа хийж холбогдох арга хэмжээг авч ажиллаа.

Амны хаалт 1500ш, нойтон сальфетка 25ш, санитол 5л, гар ариутгагч зэрэг халдвар хамгааллын хэрэгслийг нийт ажилтнууд, ажлын байруудаар тараалаа.

Салбар дотооддоо 111 ажилтнаас түргэвчилсэн оношлуурын шинжилгээ авсан.

Байнгийн жижүүртэй 9 дэд станц болон конторын өрөө тасалгаа, цайны газар, сургалтын полигон, засварын байранд 7 хоногт 2 удаагийн давтамжтайгаар ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Байнгийн жижүүргүй 5 дэд станцад 7 хоногт 1 удаа ариутгал хийгдэж байна.

2021.12.14-ны өдрийн байдлаар салбарын хэмжээнд COVID-19 вакцины 3-р тунд 183 ажилтан хамрагдаж 85,1% үзүүлэлттэй байна.

Эрүүл хооллолт, халдварт бус өвчлөлийн талаар зайн сургалт, ямар шинж тэмдэг илэрвэл та ходоодоо дурандуулах шаардлагатай вэ? нийтлэл, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэсэн эд зүйлсийг хэрхэн аюулгүй зайлуулах вэ?, сэдэвт Нийгмийн эрүүл мэндийн төвийн зурагт санамж, зөвлөмж, ажлын байрны дасгал хөдөлгөөн бичлэгийг цахим орчинд салбарын FACEBOOK групп, абле программ хангамжийн ОЛОН НИЙТ хэсэгт байршуулж нийт ажилтнуудад уриалга, сурталчилгаа явууллаа

Хоёр. Ашиглалтын түвшин, найдвартай ажиллагаа дээшлүүлэх, засварын бэлтгэл ажлыг хангах талаар

А. АГААРЫН ШУГАМ:

Төлөвлөгөөт их засварын ажлуудаас

220 кВ-ын 208-р агаарын шугамын их засварын ажлыг 13 хүний бүрэлдэхүүнтэй 2 бригад 5 хоногийн хугацаанд Тулгуур №228-261 хүртэл 30 тулгуурт 3 фазын 1328 ширхэг бохирдлого ихтэй элементийг ПС-70 маркийн шинэ элементээр солих ажил,



110 кВ-н Бугант агаарын шугамын Тулгуур №101-115 хүртэл 14 пролёт буюу 3.9 км урт трассын 18м өргөнтэй нийт 70200 м2 талбайн трасс цэвэрлэгээний ажлыг 2021 оны 10 сарын 18-аас 2021 оны 10 сарын 21-н хооронд 4 хоногийн хугацаанд тус тус хийж гүйцэтгэлээ

2021 оны 09-р сараас – 11-р сарыг дуустал хугацаанд Агаарын шугамын үзлэгээр:

110 кВ-ын Ерөө АШ-ын нийт уртын дагуу болон тасралтын зонд Т№110-190-н хооронд, Т№125-100, 156-186 хооронд өндрийн үзлэг хийж, Т№142-ын В,С-фаз, Т№144-ын С-фаз, Т№145-ын С-фаз, Т№155-ын С-фаз, Т№106-ын В-фазын элемент хагархайг сольж, Т№121-ын шувууны үүр авч, Т№140-ын С-фаз, Т№142-ын С-фаз, В-фазын нэвт цохигдсон элементийг сольж гэмтэл устгах

УБ-208 АШ-ын Т№400-280, Т№1-320 хүртэл ээлжит бус эргүүл үзлэг хийсэн. Үзлэгээр АТ№394-н Вф, Т№384-н Сф, Т№371-н Сф-д 1ш элемент хагархай, Т№1-280 хүртэл Жаргалант сумын харъяа хамгаалалтын зурваст буусан айлуудад мэдэгдэх хуудас тараасан.


116-р АШ-ын Т№1-110, 115-р АШ-н Т№254-161-н хооронд ээлжит бус эргүүл үзлэгийг АШ-ын монтёр Э.Энхтайван бригад хийсэн, илэрсэн гэмтэлгүй.

110 кВ-ын Баясгалант АШ-ын нийт уртад ээлжит эргүүл үзлэгийг Д.Батзоригийн бригад хийв. Үзлэгээр Т№353,384-шүүртэй, Т№372-ын траверсын голоос мяндсан утас унжсан зөрчил илрүүлсэн.

Дэд станцын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлуудаас

220/110/35 кВ-ын Дархан дэд станцын их засварын ажлаар АТ-1-н 110кВ-н ТТ-ын А фазын оруулга сольж, 2 термосфоны фильтерийн силикагель, 3-р групп хөргөлтийн насос сольж, 3ш радиоторын хөргөлт задлаж цэвэрлэж, 220,110 кВ-ын оруулагуудад цэвэрлэгээ, үйлчилгээ,чангалгаа хийж, 800л тос нэмэж, АТ-2 трансформаторыг бүрэн будах ажлууд

110/6 кВ-ын Үйлдвэр дэд станцын яч №3,4-ын НОЛ-1, 2-ыг буулгаж, гарсан шугамын ячийг-д ВК-10 маркын тосон таслуур суурилуулж, Яч№3-ын шинний холболт, губка, хөшигний тохиргоо хийж, ГТ-ыг суурилуулж гэмтлийг устгасан. Мөн 110/35/6 кВ-ын Хөтөл дэд станцын Т-1-н ТТ-н Сф-д хий нэмж, ВМТ-1 даралт 7,9 ата болгож, Т-2-н 6кВ-н шинийн тулах изолятор 5ш цуурсан байсаныг сольж гэмтэл устгалтын ажлуудыг хийж гүйцэтгэв.



ДҮТ ТӨХХК-ийн 2021.09.14-ний 02/1221 тоот албан бичгийн дагуу 110/35/6 кВ Сүхбаатар, Зүүнхараа 220/110/35 кВ Дархан дэд станцын Хөтөл-А, Б АШ, 110/35/10 кВ Баруунхараа, Борнуур, 110/6 кВ Үйлдвэр, Бурхант дэд станцуудын өвлийн их ачааллын АЧР-н тавил шалгах ажлыг 2021.09.22-27-ны хооронд РХА-н инженер О.Амартүвшин, Бугант, Орхон, Сүхбаатар, Давхар, Шарын гол дэд станцуудын ОД КЗ-ын ажиллагааг шалгаж тохируулах, тос нэмэх ажлыг монтёр Х.Батсүрэн, Б.Сүхчулуун, Б.Саранболд нарын бригад тус тус хийж гүйцэтгэсэн.



220/110/35 кВ Дархан дэд станцын 201, 202, 208-р АШ-н РХАБ-г МП-н реле хамгаалалтаар шинэчлэх ТЗБАХ-н ажлыг РЗА ХХК хийж гүйцэтгэсэн. ТЗБАХ-н ажилд РЗА ХХК, ДҮТ ТӨХХК, ЦДҮС ТӨХК ТБС-н РХА-н инженерүүд РХА-н тавил, схемийн дагуу хамтарсан шалгалт хийж ажиллагаанд бүрэн оруулсан. Мөн 220/110/35 кВ Дархан дэд станцын 257, 258-р АШ-н бэлтгэл хамгаалалтыг МП-н РХ-р сольж, зэрэгцээ ажиллагаанд оруулах ажилд РХА-н инженер Д.Түвшиндорж 2021.11.01-08-ны хооронд хяналт тавьж ажилласан байна.



Гурав. Цаг үеийн ажлын талаар

Дархан хот байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд ДУА-ын Дархан сумын онцгой комиссын шийдвэрээр инженерийн байгууламжийн үерийн даланг цэвэрлэх ажлаар 1200 метр орчим үерийн далангийн 630 м3 шороог зөөвөрлөн зайлуулсан. Мөн “Миний монгол цэцэрлэгт хүрээлэн” - ийн “Бумбын орд”-ыг засварлан тохижуулж хүлээлгэж өгсөн.



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Дасгал, зааварчилгааны талаар Салбарын хэмжээнд нийт 2 шинэ ажилтанд урьдчилсан зааварчилгааг, 25 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгааг, 3625 ажилтанд өдөр тутмын зааварчилгааг, 280 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгааг, ээлжит бус зааварчилгааг 300 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын харъяа дэд станцууд болон алба хэсгүүд дээр аваари эсэргүүцэх дасгалыг 18 удаа явуулж нийт 166 ажилтан, осол эсэргүүцэх дасгалыг 8 удаа явуулж нийт 92 ажилтан, гал эсэргүүцэх дасгалыг 12 удаа явуулж нийт 128 ажилтан хамрагдсны зэрэгцээ салбарын 3-р улирлын АЭД-ыг төлөвлөгөөний дагуу “110/35/6 кВ-ын Мөрөн дэд станц дээр 110 кВ-ын Тэлмэн ЭТ гэмтсэн үед авах арга хэмжээ” сэдвээр, ГЭД-ийг “Мөрөн дэд станцын удирдлагын шитэнд гал гарсан үед авах арга хэмжээ” сэдвээр, 4-р улирлын АЭД-ыг Булган дэд станц дээр “110 кВ-ын Мөрөн ЦДАШ-ын тулгуур унасан үед авах арга хэмжээ”, ГЭД-ийг “Булган дэд станцын реле хамгаалалтын зааланд гал гарсан үед авах арга хэмжээ” сэдвээр тус тус явуулж, дасгалын мөрөөр авах арга хэмжээг төлөвлөн ажиллалаа.

Мөрөн дэд станц дээр явуулсан гал эсэргүүцэх дасгалын үеэр галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм зааврын мэдлэгийн талаар АХА тэмцээн зохион явууллаа. Энэхүү тэмцээнд Мөрөн дэд станцын ээлжийн техникч Л. Доржням түрүүлсэн байна.



2021.11.13-нд өдөр ШЗХ-с III улиралын АЭД-г манай салбарт зохион байгууллаа. 110/35/10кВ-ын Булган дэд станцын Т-1 трансформаторын 10кВ талын В, С фазын хооронд муур орж, дифференциал хамгаалалт ажилласан үед авах арга хэмжээ сэдвээр зохион байгуулж Салбарын диспетчер инженер Л.Отгонбаяр, ээлжийн техникч Б.Мөнхцэцэг болон 12 дэд станцын 34 хүн оролцлоо.



ХАБЗА-н бүх шатны үзлэгийн талаар: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 121 удаа хийж, нийт 225 зөрчил, II шатны үзлэгийг 22 удаа явуулж нийт 67 зөрчил, III шатны үзлэгийг нийт 4 удаа хийж, нийт 36 нэрийн зөрчлүүдийг илрүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч, устгуулах арга хэмжээг авч ажиллалаа.

Наряд, шийдвэрээр хийсэн ажлын талаар: Салбарын харъяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 153, шийдвэрээр 259 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 1104 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Ажлын байрны эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ компанийн хэмжээнд хийгдэж байгаатай холбогдуулан 11сарын 25-ны өдөр WNA компанийн ажилтнуудтай хамтарч ажиллан, хэмжилтүүдийг хийлгэх, бичиг баримтуудыг танилцуулах, харилцан ярилцлага хийх ажлуудыг зохион байгууллаа.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Эрдэнэт дэд станцын 200 МВА-ийн АТ-1 автотрансформаторын их засварын ажлыг Украин улсын ЗТЗ сервисийн мэргэжилтэнтэй хамтран ЦДҮС ТӨХК-ийн ХБС, ТХХ, ТБТХ-ийн ажилтнууд амжилттай хийж гүйцэтгэн хүчдэлд залгав.



Баянхонгор дэд станцын 2.5 МВА чадалтай Т-3 трансформаторыг 10 МВА чадалтай трансформатораар сольж, ЗӨБС-аас буусан 3.3 МВАрын компенсаторыг зөөвөрлөн суурилуулж хэмжилт туршилтыг хийж хүчдэлд залгав.



Дараах цахилгаан дамжуулах агаарын шугамуудын РХАБ-ийг иж бүрэн шинэчилсэн. Үүнд:

Эрдэнэт дэд станцын 35кВ-ын Город-Б
Эрдэнэт дэд станцын 35кВ-ын Очистный-Б
Эрдэнэт дэд станцын 35кВ-ын Карьер-Б
Арвайхээр дэд станцын 35кВ-ын Тарагт
Арвайхээр дэд станцын 35кВ-ын Зүүнбаян-Улаан

Тосонцэнгэл дэд станцын 10кВ-ын Төмөрбулаг
Тосонцэнгэл дэд станцын 10кВ-ын Тосонцэнгэл

Эрдэнэт дэд станцын 220кВ-ын 201, 202-р АШ-ын РХА-ийн байгууламжийн үндсэн хамгаалалтыг ОХУ-ын Бреслер-0107 маркийн релегээр, бэлтгэл хамгаалалтыг АНУ-ын SEL-411L маркийн релегээр сольж шинэчлэх ажил хийгдэв.



Мөрөн дэд станцад 110кВ-ын Мөрөн ЦДАШ-ын LB6-110GYW2 (100/5) маркийн гүйдлийн трансформаторыг ТФЗМ-110Б-III-У1 (300/5) маркаар солив.




Хишиг-Өндөр, Тосонцэнгэл дэд станцуудад 35кВ-ын ХТ-1 трансформаторт НУ5WZ-51/134 маркийн цэнэг шавхагч, RXWO (0.5A) маркийн гал хамгаалагч нэмж суурилуулав.



110 кВ-ын Хархорин-А, Б шугамын алгасалт ихтэй ПС-110 маркийн 730, 731-р тулгуурыг У-110-2+5 маркийн анкер тулгуураар солих ажил хийгдсэн.





ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бүх төрлийн дасгалын явц, түүний чанар, зааварчилгааны мөрдөлтөнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2021 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд 27 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 1812 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 2628 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 13766 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаад байна.

2021 оны 3-р улирлын ХАБЗА, ашиглалт засварын III шатны үзлэгийг ковид-19 вирусын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 11 сарын 06-наас 2021 оны 11 сарын 25-ны өдрүүдэд Багануур, Хот, Төв, Өндөрхаан, Баянмөнх, Бор-Өндөр, Чойр, Айраг, Сайншанд, Ширээт, Замын-Үүд, Борхойн дэд станцууд болон АШҮА, ЗА,

РХАХТА, СЭЗА, ЗАА-н албадуудад хийж нийт 161 зөрчил илрүүлж хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. 2021 оны 2-р улирлын III шатны үзлэгийн гүйцэтгэл 84.95 хувьтай гарсан байна.

Эрчим хүчний яамнаас ирүүлсэн ЭБЦТС ТӨХК, БЗӨБЦТС ТӨХК-нд гарсан ослын мэдээлэл даалгаварууд, компаниас ирүүлсэн зөвлөмж №09, 10 болон ковид-19 вирусын эсрэг ажилтнуудыг дархлаажуулалтын нэмэлт 3-р тунд хамруулах сарын аяны хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулж, үүний дагуу хийгдсэн ажлын тайлан, гүйцэтгэлийг компанийн хяналт мониторингийн хэлтэст тухай бүр хугацаанд нь албан бичгээр хүргүүлж ажилласан.

Ковид-19 вирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор коронавирусын эсрэг вакцинжуулалтанд 1, 2-р тунд

нийт 201 ажилтнаас 200 ажилтан бүрэн хамрагдаж 99.5 хувийн гүйцэтгэлтэй, дархлаажуулалтын нэмэлт 3-р тунд 201 ажилтнаас 160 ажилтан буюу 79.6 хувийн гүйцэтгэлтэй хамрагдсан байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг салбарын хэмжээнд 12 дэд станцын барилга байгууламж, албан конторууд, авто гражууд, машин механизмуудыг бүрэн хамруулж нийт 18000 гаруй метр квадрат талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

Салбарын хэмжээнд коронавирусын халдвар, эдгэрэлт, тусгаарлалт, харьяа дэд станцуудын орон нутгийн онцгой комиссын шийдвэр, халдварын тоо, нөхцөл байдлын талаарх мэдээллийг компанийн гамшгаас хамгаалах штабд тогтмол хугацаанд мэдээлэл өгч ажиллаж байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ЗАСВАРЫН АЖЛААР

2021 оны 12 сарын 01 ний байдлаар хийгдсэн засварын ажлын мэдээ

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Их засвар	19	118	94.7%
ТЗБАХ	10	10	100%
Урсгал засвар	210	210	100%
Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил	181	359	199%
Аянгын улирлын	93	93	100%
Гэмтэл устгах ажлаар		81	

ТЗБАХ-ЫН АЖЛААР

2021 оны тодотгосон төлөвлөгөөгөөр 10 ажлыг графикт хугацаанд хийж гүйцэтгээд байна. ТЗБАХ-ний ажлуудаас 220/110/35 кВ Багануур дэд станцын 220 кВ ИХБ-н схемийн өөрчлөлт хийх, мөн 220 кВ ДЗШ УРОВ шинээр суурилуулах 110/35/10 кВ Сайншанд дэд станц ДХТ-1,2 0.4 кВ панель иж бүрэн шинэчлэх, 110/35/10 кВ Айраг дэд станц 110 кВ Чойр, Сайншанд ШуС шинэчлэх, 220/110/35/6 кВ Чойр дэд станцад авто кранд граж барих, зэрэг томоохон ажлууд хийж гүйцэтгээд байна.

ИХ ЗАСВАРЫН АЖЛААР

Тодотгосон төлөвлөгөөгөөр 19 ажил төлөвлөснөөр Багануур конторын гадна фасад болон 2 давхрын зүүн жигүүр засварлах ажил үргэлжлэн хийгдэж байна.

Бусад ажил 100 хувь гүйцэтгэлтэй хийгдсэн их засвараар 110 кВ Замын-Үүд ЦДАШ-н 18 км дамжуулагч утас солих ажил, 110 кВ Өндөрхаан ЦДАШ-ын анкер будах, 110/35/10 кВ Айраг дэд станцын барилгын дээвэр засварлах, 110/35/6 кВ Өндөрхаан дэд станцын барилгын засвар хийх үүдний хэсэг барих зэрэг томоохон ажлууд хийж гүйцэтгээд байна.



220/110/35кВ "Багануур" дэд станцын 220 кВ ИХБ-ын схемийн өөрчлөлт хийж анхдагч хэлхээний схем болон РХА-ын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.



110/6 кВ Хот дэд станцын Т-2 110 кВ нэвчилтийн гүйдэл өндөр байсан ЦШ-г шинээр сольсон. Мөн 110/35/10 кВ Айраг дэд станцад ашиглалтын шаардлага хангаагүй 110 кВ Чойр, Сайншанд ШуС шинэчлэн тоноглолын найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.



110/35/10 кВ Сайншанд дэд станцын ДХТ-1,2 0.4 кВ панель иж бүрэн шинэчлэн, АУРА төхөөрөмж суурилуулж ажилд бэлэн болгон хүчдэлд залгасан.



220/110/35/6 кВ Чойр дэд станц 25 тн камаз кранд граж шинээр бариж ашиглалтад хүлээн авсан.



220/110/35/6 кВ Чойр дэд станц ПАРМА төхөөрөмжид 1 ширхэг гүйдлийн блок нэмж 35 кВ гарсан шугамуудыг холбов.



ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2021 оны 09, 10, 11 дүгээр саруудад нарыдаар 73, шийдвэрээр 176 ажил хийгдсэн. Наряд шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 13 удаагийн дасгал зохион байгуулагдаж 178 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 183 хүн, тухайлсан зааварчилгааг 2196, ээлжит бус зааварчилгааг 304 хүнд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 563 удаа хийж 24 зөрчил, II шатны үзлэгийг 23 удаа хийж 54 зөрчил, III шатны үзлэгийг 14 ажлын байранд 2 удаа хийж 115 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 48 удаа хийж зөрчил дутагдлыг арилгаж ажилласан.


ХАБЭА-н III шатны үзлэгээр үнэлэгдсэн ололттой, дэвшилтэд санал санаачилга:

1. Тавантолгой дэд станцын ажилтнууд

бүтээлч ажлын хүрээнд ОПУ-д байгаа галын хорнуудын дэргэд 5 кг-р ууталж, хаягжуулсан элс байрлуулсан нь болзошгүй аюулын үед хэрэглэхэд хялбар, бусад ажлын байр бүрт нэвтрүүлж болох санал санаачилга болсон.



2. Оюутолгой дэд станцын ажилтнууд ХАБЭА-н багаж хэрэгсэл нэг бүрт өөрийн дэд станцын нэр хаягийг нааж хаягжуулсан байна. Энэ нь багаж хэрэгсэлүүд салбарын төвд ирж ӨХТХ-ийн лабораторид туршигдахад хоорондоо солигдохгүй байх зөв шийдэл болсон. Цаашид бусад дэд станц бүр өөрсдийн хэрэглэдэг нэг төрлийн багаж хэрэгсэл бүрийг хаягжуулах саналыг гаргасан.



3. Салбарын хэмжээнд 4ш ариутгалын төхөөрөмж автомаксаар ХАБЭА-н инженерүүд болон дэд станцын АШУ-ний инженерүүд хариуцан ариутгал халдваргүйжүүлэлтийг жавельоны уусмал ашиглан 14 хоног тутамд хийж байна.



Ажилтнуудыг дархлаажуулалтын III тунд хамруулахаар 2021 оны 11 сарын 15-ны өдрөөс төлөвлөгөө гарган мөрдөж ажилласан. Салбарын хэмжээнд 110 ажилтан ажиллаж байгаагаас дархлаажуулалтын I тунд 108 ажилтан /98.18%/, II тунд 106 ажилтан /98.15%/, III тунд 83 ажилтан /78.3%/-ны хамрагдаад байна.

Дархлаажуулалтын II тунд хамрагдсан 106 ажилтнаас 25 ажилтан III тундаа хамрагдсан байсан. Сарын аяны хүрээнд 81 ажилтан III тунд хамрагдах төлөвлөгөө гарган ажилласнаас 58 ажилтан хамрагдаж төлөвлөгөөний биелэлт 71.6%-тай байна. III тунд хамрагдаагүй байгаа 23 ажилтан байгаагаас өөрийн хүсэлтээр хамрагдахгүй 3, эмчийн заалтаар хамрагдахгүй 1, ковид-19 вирусын халдвар авч эдгээд 21 хоног болоогүй, бие, эрүүл мэндийн байдалд өөрчлөлт орсоны улмаас тодорхой хугацааны дараа хийлгэх 19 ажилтан байна. Эдгээр 19 ажилтаныг 2021 онд багтаад III тунд бүрэн хамруулах ажлын зохион байгуулалтыг хийж байна.

Салбарын харьяа ажлын байр бүрт осол үүсгэж болзошгүй хүчин зүйлийг үнэлж, эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН ДЭЭШЛҮҮЛЭХ, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД:

110/35/10 кВ-н Даланзадгад дэд станцын ИХБ-нд хайрга дэвсэх ажлыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд бүрэн хийж гүйцэтгэсэн. Говийн шаварлаг хөрстэй тоосжилт ихтэй газарт хайрга дэвсэх арга хэмжээг авснаар тоноглолын бохирдол болон зуны улиралд борооны ус тогтох нөхцөлийг бууруулсан



Салбарын бүс нутгийн хэмжээнд 2021 оны хавар өмнөх жилүүдээс шороон шуурга ихээр шуурсантай холбогдуулан дэд станцын ИХБ-н тоноглол, тоноглолын удирдлагын шкафууд, дэд станцын хашаа, кабель шугамын лоткинд элс дүүрсэн. Салбарын харьяа дэд станцуудын элс шорооны цэвэрлэгээг хийж, удирдлагын шүүгээ, клемний шкафуудын битүүмжлэлийг сайжруулсан



220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцын РХ-н селектив ажиллагааг хангах, найдвартай ажиллагааг дээшлүүлэх зорилгоор салбарт анх удаа компанийн ODOH маркийн 3000 А хүртэл анхдагчаар шахах чадалтай багажаар 220/110 кВ ДЗШ-н ажиллагааг шалгав. 110 кВ-н I СШ-н хамгаалалтын ажиллагааг гаргалгаа бүрт анхдагчаар гүйдэл шахах шалгав. 110 кВ-н I СШ-н хамгаалалтын ажиллагааг шалгах аар 110 кВ-н ТойТ-д анхдагчаар гүйдэл шахах үед 110 кВ-н II СШ-н таслууруудыг тасалсан угсралтын алдааг илрүүлж хэвийн болгов. ДҮТ ХХК-тай хамтран 110 кВ-н шинийн хамгаалалтын SEL-487B релений дотоод функцыг судалж, дотоод функцын тохиргоог засав.

110/35/10 кВ Даланзадгад дэд станцын 10 кВ-н ячейкуудын кабель оруулгын насжилт өндөр цаашид ачаалал өсөн нэмэгдэж байгаа тул нуман гэмтлийн үед шуурхай ажиллагааны ажилтнуудын аюулгүй байдал тоноглолын гэмтлийг хамгийн бага байлгах зорилгоор бие даасан нумын хамгаалалтыг дохиоллын хэлхээний хамт ажилд оруулав.



Их засварын ажлаар 110/35/10 кВ Даланзадгад дэд станцын 35 кВ-н ХТ-2-н хөнгөнцагаан кабелийг хүчдэлийн трансформаторын дээд шкаф, дээд шкафаас панель №7 хүртэл нийт 270м зэс кабелиар сольж монтажлав.

СВК-н хөргөлтийн системд гэмтэл гарч үзлэг хийхэд СВК-1-н хөргөлтийн системийн усны насосны 0,4 кВ-н тэжээлийн хэт ачааллын хамгаалалтын реле гэмтсэн байсныг илрүүлж гэмтлийг устгасан

Бүтээн байгуулалтын ажлаар

Монгол улсын старатегийн чухал орд газар болох Тавантолгойн нүүрсний уурхайг тэжээх 110/35/6 кВ Цанхи дэд станцад 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Эрчим хүчний хөгжлийн төв, эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, ЦДҮС ТӨХК, Грийн инержи ХХК-ийн хамтарсан техникийн комисс ажилласан. Тус техникийн комиссын шийдвэрээр 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцаас 110 кВ Цанхи-А, Б АШ-аар 110/35/6 кВ Цанхи дэд станцыг туршилтын хүчдэлд амжилттай залгасан.

110/35/6 кВ Цанхи дэд станцыг хүчдэлд

залгахтай холбогдуулан 220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад 110 кВ Цанхи-А, Б АШ-н реле хамгаалалтын тавил тохиргоог хийж, хамгаалалтын ажиллагааг шалгах ажлыг тус салбарын РХАХТА-ны ажилтнууд хийж гүйцэтгэсэн.

220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад төмөр замын 35 кВ Зэрэглээ-А,Б гаргалгааны тоноглол суурилуулах, холболт хийх ажлыг “Эрчим инженеринг” ХХК хийж гүйцэтгэсэн.



Цаг үеийн ажлаар:

Банк санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтны өдрөөр тус салбарын СЭЗА-ны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Э.Оюунбат нь нягтлан бодох бүртгэлийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдлаа. Э.Оюунбатдаа ажил хөдөлмөрийн өндөр амжилт, эрүүл энх, саруул сайхан бүхнийг хүсэн ерөөе.




ТӨВ УДИРДЛАГА

“ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”- ИЙН ЗӨВЛӨХИЙН ГЭРЭЭГ БАЙГУУЛАВ.

ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны санхүүжилтээр хэрэгжих “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн зөвлөхөөр шалгарсан Герман улсын Integration Umwelt& Energie компанитай “Зөвлөх үйлчилгээний” гэрээ байгуулав. Гурвалсан тус гэрээнд Зөвлөх компанийн төлөөлж Integration Umwelt& Energie компанийн захирал Ральф Фортнер, ЭХЯ-ыг төлөөлж Хуулийн хэлтсийн дарга

Л.Мөнхжаргал, ЦДҮС ТӨХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нар гарын үсэг зурсан. Гэрээ байгуулах ёслолд KfW банкы менежер Лоренц Геснер, Монгол улс дахь салбарын захирал Майкл Самсер-Хельштерн, зохицуулагч Ц.Энхзул болон ЦДҮС ТӨХК-ийн удирдлагууд, ТХН-ийн ажилтнууд оролцлоо.



КОМПАНИЙН 2021-2022 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАГДЛАА

Монголын Эрчим хүч, геологи, уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, салбарын ажил олгогч эздийн байгууллага хооронд байгуулсан “Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын 3 талт хэлэлцээр”-ийг үндэслэн өнөөдөр компанийн Захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн хороо 2021-2022 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээг байгууллаа. Хамтын гэрээг байгуулахад Захирааг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваа, Нийгмийн асуудал, төсөл хөтөлбөр хариуцсан дэд захирал А.Азбаяр болон салбарын, зарим хэлтсийн дарга нар, компанийн ажилтнуудыг төлөөлж компанийн ҮЭХ-ны дарга Ц.Мөнхбаатар, салбаруудын ҮЭХ-ны дарга нар, тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажууллаа. Энэ удаагийн хэлэлцээрээр хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарим нэмэлт өөрчлөлтүүд оруулж ажиллах асуудал дээр талууд санал нэгдсэн болно.

ҮЭХ-НЫ ДАРГААР УБС-ЫН АШУА-НЫ АШИГЛАЛТЫН
ИНЖЕНЕР Ц.МӨНХБААТАР СОНГОГДОО.

“ЦДҮС” ТӨХК-ийн Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны бүх гишүүдийн тайлангийн хурал 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр УБЦТС ТӨХК-ийн хурлын зааланд цахимаар болон заалнаас гэсэн хосолсон хэлбэрээр амжилттай болж өндөрлөв. Бүх гишүүдийн хуралд арван гишүүн тутмын нэг нь төлөөлөгчөөр сонгогдон оролцлоо

Компаний ҮЭХ-н дарга Д.Цэрэндамба “2017-2021 оны компаний ҮЭХ-ны үйл ажиллагааны тайлан”-г тавьж хэлэлцүүлэв.

Компаний ҮЭХ-н хяналтын хорооны тайланг Э.Ганхуяг танилцуулав.

Компаний салбар ҮЭХ-ны дүрэм шинэчлэн батлав.

Компаний ҮЭХорооны орон тооны дарга, идэвхтэн сонгуультнуудыг шинээр сонгох /ҮЭХ-н дарга, хяналтын хорооны гишүүд, эмэгтэйчүүдийн хэсгийн дарга, залуучуудын хэсгийн дарга, ҮЭХ-ны дэргэдэх ХАБЭА төлөөлөгч/ зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.


Компаний ҮЭХ-н даргаар УБС-ын АШҮА-ны ашиглалтын инженер Ц.Мөнхбаатар, Хяналтын хорооны гишүүдээр ГБС -ын РХА-ны дарга Т.Цэнгэл, УБС-ын санхүүгийн албаны эдийн засагч Ж.Болорцэцэг, ЗАА-ны жолооч Д.Батбогд, Санхүүгийн албаны үндсэн хөрөнгийн ня-б. компаний РХХТ-ын хэлтэсийн РХА-ын инженер ХАБЭА-н инженер Б.Батчулуун нар нийт гишүүн ахлаа хүлээн авлаа.



ЦДҮС ТӨХК “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачилсан. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулж буй хэрэг билээ. Энэхүү аяны хүрээнд Эрчим хүчний сайд Н.Тавинбэхийн салбарын хамт олондоо 100,000 мод тарих уриалгыг дэмжиж, Эрчим хүчний яам болон салбарын зарим үйлдвэр, компаниуд 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр аяныг эхлүүлээ. Нийслэлийн Налайх дүүрэгт 720 ширхэг Монос мод тарихад компанийн төв удирдлага болон Улаанбаатар салбарын ажилтнуудын төлөөлөл буюу 40 ажилтан нийт 96 мод суулгасан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд компанийн бусад салбарынхаа ажилтнуудыг идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмрээ оруулахыг уриалж байна.





ТӨВ КОМПАНИ БОЛОН САЛБАРУУД СПОРТЫН 5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Уламжлалт 5 төрөлт тэмцээнээ төв удирдлага болон салбарууд 2021 оны 12 дугаар сард амжилттай зохион байгуулж аваргуудаа тодрууллаа. Коронавируст халдварын нөхцөл байдлаас үүдэж энэхүү тэмцээн өнгөрсөн жил цуцлагдаад байсан билээ. Сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, билльярд, шатрын 5 төрлөөр ажилтан, албан хаагчид авхаалж самбаагаа сорьсон юм. Тэмцээнд идэвхи, санаачлагатай оролцсон бүх баг тамирчид, хамт олондоо талархал илэрхийлж ажлын амжилт хүсье.



ТӨВ УДИРДЛАГА

Сагсан бөмбөг	
Эрэгтэй	Эмэгтэй
1. ШЗХ	1. ЗУХ
2. РХАХТХ	2. ТБТХ
3. ТХХ	3. СЭЗХ

Гар бөмбөг	
Эрэгтэй	Эмэгтэй
1. ШЗХ	1. СЭЗХ
2. МТХ, СЭЗХ /хамтарсан баг/	2. ТБТХ
3. РХАХТХ	3. ХМХ, РХАХТХ,ТХН,МТХ

№	Билльярд	№	Шатар	№	Теннис
1	РХАХТХ	1	НҮТМХ	1	РХАХТХ
2	ТБТХ	2	МТХ	2	ТБТХ
3	ЗУХ	3	ХМХ	3	МТХ

УЛААНБААТАР САЛБАР

Д/д	Тэмцээний төрөл	Байр	Байр эзэлсэн ажилтан, баг
1	Биллиард /эрэгтэй/	1-р байр	М.Мөнх-Очир /АШҮА/
		2-р байр	Ц.Ганбат /АШҮА/
		3-р байр	О.Батболд /АШҮА/
	Биллиард /эмэгтэй/	1-р байр	Д.Мөнх-Ундрах /АШҮА/
		2-р байр	Л.Балжинням /АШҮА/
		3-р байр	О.Алтанчимэг /АШҮА/
2	Шатар /эрэгтэй/	1-р байр	Э.Төгөлдөр /АШҮА/
		2-р байр	Н.Жаргал /АШҮА/
		3-р байр	Э.Наранбат /РХАХТА/
	Шатар /эмэгтэй/	1-р байр	Г.Оюундэлгэр /АШҮА/
		2-р байр	Ц.Сувдмаа /СЭЗА/
		3-р байр	Э.Одбал /РХАХТА/
3	Ширээний теннис /эрэгтэй/	1-р байр	Б.Тэмүүжин /АШҮА/
		2-р байр	Б.Энх-Амгалан /АШҮА/
		3-р байр	М.Майхүү /ЗААА/
	Ширээний теннис /эмэгтэй/	1-р байр	Б.Болортуул /АШҮА/
		2-р байр	Э.Одбал /РХАХТА/
		3-р байр	Ч.Даваажаргал /РХАХТА/
4	Гар бөмбөг /эрэгтэй/	1-р байр	Засварын алба
		2-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай
		3-р байр	Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба
	Гар бөмбөг /эмэгтэй/	1-р байр	Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба-Санхүү, эдийн засгийн алба
		2-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай
		3-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай
5	Сагсан бөмбөг /эрэгтэй/	1-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай
		2-р байр	Засварын алба
		3-р байр	Захиргаа, аж ахуйн алба
	Сагсан бөмбөг /эмэгтэй/	1-р байр	Реле хамгаалалт автоматик, хэмжилт, туршилтын алба-Санхүү, эдийн засгийн алба
		2-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай
		3-р байр	Ашиглалт, үйлчилгээний алба шуурхай

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

Спортын тэмцээний эрэгтэй, эмэгтэй биллиардны төрөлд:

1-р байранд Суудлын автомашины жолооч Г.Ариунболд
2-р байранд Салбарын ерөнхий инженер Б.Түвшинбаяр
3-р байранд Борхойн дэд станцын Ээлжийн монтер Х.Эрдэнэмөнх
1-р байранд Борхойн дэд станцын ээлжийн монтер Д.Хулан
2-р байранд СЭЗА-ны Цалин хөлсний нягтлан бодогч Д.Сэлэнгэ
3-р байранд Хот дэд станцын Ээлжийн техникч А.Хоролгарав

Спортын тэмцээний эрэгтэй, эмэгтэй теннисний төрөлд:

1-байранд Сайншанд дэд станцын ээлжийн монтер М.Жамсран
2-р байранд Автобусны жолооч Ц.Батмөнх
3-р байранд Өндөрхаан дэд станцын ээлжийн техникч Б.Мөнхжаргал
1-байранд ЗААА-ны Бичиг хэрэг, архивч Р.Энхмаа
2-р байранд Замын-Үүд дэд станцын ээлжийн техникч Б.Отгонцэцэг
3-р байранд Хот дэд станцын ээлжийн техникч М.Санчирмаа

Спортын тэмцээний эрэгтэй, эмэгтэй шатарын төрөлд:

1-байранд Борхойн дэд станцын Ээлжийн монтер Х.Эрдэнэмөнх
2-р байранд Чойр дэд станц сахиул С.Отгонсүрэн
3-р байранд Салбарын ерөнхий инженер Б.Түвшинбаяр
1-байранд Албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Б.Түвшинжаргал
2-р байранд Чойр дэд станц Ээлжийн техникч Б.Баришир
3-р байранд Бор-Өндөр дэд станцын Ээлжийн техникч Г.Эрдэнэсүвд

Спортын тэмцээний эрэгтэй, эмэгтэй холимог гар бөмбөгийн төрөлд:

1-р байранд Сансар баг
2-р байранд Оч-Хүч баг
3-р байранд Шанд-Транско баг

Спортын тэмцээний эрэгтэй, эмэгтэй холимог сагсан бөмбөгийн төрөлд:

1-р байранд Эрчим баг
2-р байранд Титэмт-Тулга баг
3-р байранд Смарт-Сүлжээ баг

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

	Сагсан бөмбөг	Волейбол	Теннис эр/эм	Билльярд эр/эм	Шатар эр/эм
1-р байр	Хэсэг-Дэд станцууд	Хэсэг-Дэд станцууд	П.Даваасүрэн Ж.Төмөрсанаа	М.Бат-Эрдэнэ О.Сарангоо	Г.Баттөмөр Г.Оюумаа
2-р байр	РХАХТА-СЭЗА	ЗА	Ж.Анхбаяр П.Наранцэцэг	Г.Ууганбаяр Б.Ундрах	Б.Батцогоо Г.Нандинцэцэг
3-р байр	ЗААА	Удирдлага-ИХ	Г.Ууганбаяр Г.Гэрэлтуяа	М.Эрдэнэбаяр Ч.Туул	Б.Мөнхбат Б.Хулан

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

Шатар: эрэгтэй

1-р байр – РХАХТА-ны Реле хамгаалалт, програмчлалын инженер Э.Амартүвшин

2-р байр – Сүхбаатар дэд станцын ээлжийн монтер Б.Шинэтер

3-р байр – Бурхант, Давхар, Үйлдвэр, Тосгон дэд станцын ээлжийн техникч Б.Бямба-Очир

Эмэгтэй төрөлд

1-р байр – ЗААА-ны Сургалт, бүтээмжийн инженер Б.Байгалмаа

2-р байр – Бурхант, Давхар, Үйлдвэр, Тосгон дэд станцын ээлжийн монтер Ц.Бурмаа

3-р байр – Шарынгол дэд станцын ээлжийн монтер Э.Дэлгэрмаа

Теннис: Эрэгтэй

1-р байр – Хөтөл дэд станцын ээлжийн техникч Б.Ууганбаяр

2-р байр – Хаалттай хувиарлах байгууламжийн ээлжийн инженер Х.Баттөр

3-р байр – РХАХТА-ны РХА-н монтер Х.Даваасүрэн

Эмэгтэй:

1-р байр – Дархан дэд станцын ээлжийн инженер Г.Ганцэцэг

2-р байр – Зүүнхараа дэд станцын ээлжийн инженер Б.Дэлгэр-Эрдэнэ

3- байр – РХАХТА-ны техникч М.Доржханд

Билльярд: Эрэгтэй

1-р байр – АШҮА-ны ӨҮХ-ны инженер П.Мөнхбат

2-р байр – АШҮА-ны ахлах бөгөөд АШҮ-ний инженер З.Алтансүх

3-р байр – Хөтөл дэд станцын ээлжийн монтер Л.Чинбат

Эмэгтэй

1-р байр - Бурхант, Давхар, Үйлдвэр, Тосгон дэд станцын ээлжийн техникч Г.Пүрэвням

2-р байр – ЗААА-ны Хүний нөөцийн мэргэжилтэн П.Мөнххишиг

3-р байр – Хөтөл дэд станцын ээлжийн монтер Э.Хулан

Сагсан бөмбөгийн тэмцээнд

Эрэгтэй төрөлд

1-р байр – Засварын албаны 1-р баг

2-р байр – Засварын албаны 2-р баг

3-р байр – РХАХТА-СЭЗА-ны хамтарсан баг

Эмэгтэй төрөлд

1-р байр – АШҮА-ны төвийн хэсэг

2-р байр – Шарынгол, Зүүнхараа, Баруунхараа, Борнуур дэд станцын хамтарсан “Транзит” баг

3-р байр – РХАХТА-СЭЗА-ны хамтарсан баг

Гар бөмбөгийн тэмцээнд

Эрэгтэй төрөлд:

1-р байр – РХАХТА-СЭЗА-ны хамтарсан баг

2-р байр – Засварын албана 1-р баг

3-р байр – Сүхбаатар, Дулаанхаан, Ерөө, Бугант, Хөтөл, Орхон дэд станцын хамтарсан “Тупик станц” – ын баг тамирчид тус тус байр эзэллээ.

Тэмцээний онооны системийг бага онооны зарчимаар явуулж дүнг гаргасан.

Нийлбэр дүнгээр 33 оноогоор Сүхбаатар, Дулаанхаан, Ерөө, Бугант, Хөтөл, Орхон дэд станцын хамтарсан “Тупик станц” – ын баг тамирчид “Дэд” байр

25,5 оноогоор – АШҮА-ны төвийн хэсэг “Тэргүүн” байр эзэлж шилжин явах цомын эзэн боллоо.



ӨМНӨХ ДУГААРТ МОНГОЛ БИЧГИЙН ҮНДСЭН ЗУРЛАГА, ЭГШИГ ҮСГИЙГ
НИЙТЭЛСЭН. ЭНЭ УДААГИЙН ДУГААРААР МОНГОЛ БИЧГИЙН ЦАГААН
ТОЛГОЙ БОЛОН ДЭВСГЭР ҮСЭГ, УРТ ЭГШИГ, НЭР ҮГИЙН ХУВИЛАЛЫН
ДҮРТИЙГ ХҮРГЭЖ БАЙНА.

Монгол улсад идэвхитэй ажиллаж байгаа 160 гаруй мянган төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа 2020 оны 10 сараас эхэлсэн билээ. Энэхүү судалгааг Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Үндэсний статистикийн хороо хамтран зохион байгуулж байгаа юм. Тэгвэл манай сонин компанийхаа ажилтан, албан хаагчидад үндэсний бичгийн мэдлэг олгох зорилгоор монгол бичгийн хүчээлийг цувралаар хүрээж байна.

[illegible][illegible]

НГ	их инхлэг	-	ᠨ	ᠭ
----	-----------	---	---	---

үсэг	Е	В	К	П	Ф
эхэнд	А	А	У	У	У
дунд	А	А	У	У	У
адагт	А	А	У	У	У

үсэг	З	Ц	Х	ЛХ	Ж
эхэнд	А	А	А	А	А
дунд	А	А	А	А	А
адагт	А	А	А	А	А

ДЭВСГЭР ҮСЭГ

Үгийн дунд, адарт үе төгсгөн ардаа эгшингүй ордог гийгүүлэгчийг **дэвсгэр үсэг** гэнэ. Монгол бичигт 10 дэвсгэр үсэг бий. Эдгээрийг хатуу (6), зөөлөн дэвсгэр (4) гэж ангилдаг. Зөөлөн дэвсгэрийг **МАНЛАНГ** (), хатуу дэвсгэрийг **БАГАРСАД** (**БЭГЭРСЭД**) () хэмээн тогтоовол зохино.

УРТ ЭГШИГ

Үндэсний бичигт урт эгшгийг тэмдэглэдэг хамгийн түгээмэл нийлэмж нь **эгшиг + гийгүүлэгч + эгшиг** ᠡᠭᠰᠢᠭᠡᠢᠭᠢᠭᠦ юм. Ийм нийлэмжийг уртатгал гэдэг. Монгол хэлний хөгжлийн хувьслын явцад «**ᠡᠭᠰᠢᠭᠡᠢᠭᠢᠭᠦ**» гийгүүлэгч сугарч өнөөгийн урт эгшиг үүсчээ. Жишээ нь: **ᠰᠠᠨᠠᠭ** - санаа, **ᠡᠭᠰᠢᠭ** - ээлж, **ᠬᠣᠰᠡᠨᠠᠭ** - хоршоо, **ᠡᠭᠰᠢᠭ** - цөөн

Үндэсний бичигт урт эгшгийг “эгшин + эгшин” буюу \хоёр ижил эгшин\, \хоёр өөр эгшин\ - ээр тэмдэглэх тохиолдол бий. Ихэвчлэн харь хэлнээс монгол хэлэнд орж ирсэн үгсийг дээрх нийлэмжээр тэмдэглэдэг.

Жишээ нь: $\frac{1}{1000}$ - шуудан, $\frac{1}{1000}$ - муур

НЭР ҮГИЙН ХУВИЛАЛ

Олон тооны дагавар

Монгол бичигт		Монгол хэлэнд
ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ	-ууд, -үүд	“н” -ээс бусад гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулна. Эгшиг болон н-ээр төгссөн үгэнд эр эмийг харгалзан дагуулна.
ᠨ	нар	Хүний айд хамаарах нэрд дагуулна.
ᠠᠭ, ᠠᠨ	-чууд, -чүүд, -чуул, -чүүл	Хүний айд хамаарах нэрд залгана.
ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ	-д, -с	Богино эгшигээр төгссөн үгэнд шууд залгана. Хос эгшиг болон “н”, “л”, “р” гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахад төгсгөлийн үсгийг хасна.

“Эшин” буюу богино
эгшгээр бичиж уртаар дуудах
хэлбэр нь уламжлалыг баримтлан
бичдэг цөөн үгэнд тохиолдоно.
Жишээ нь:  - агаар,
 - уурга,  - бүүвэй
Давхар бичигтгалаар  \ 
утга ялган бичнэ. Жишээ нь:
 - даах \  - дагах \

ХОС ЭГШИГ

Хос эгшгийг үндэсний бичигт үгийн эхэнд “ЭЙИ”
ᠡᠢᠨ · ᠡᠭᠡ · ᠡᠭᠡᠨ дунд ᠡᠭᠡ · ᠡᠭᠡᠨ,
адагт ᠡᠭᠡ · ᠡᠭᠡᠨ гэсэн нийлэмжээр
тэмдэглэдэг байна. Жишээ нь:
ᠡᠭᠡᠨ - айл, ᠡᠭᠡᠨᠡ - орой